

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхийлөгч,
Эрхэм гишүүд, ноёд хатагтай нар аа!

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэхийн ялдамд энэхүү Үндэсний Бага хурал нь Монгол улс авлигатай тууштай тэмцэхэд чиглэсэн дорвитой арга хэмжээ болж чадна гэдэгт итгэл төгс байна.

Хүний эрх, эрх чөлөөг дээдлэн, эрх зүйт, ардчилсан төрийн тогтолцоог бэхжүүлэх үүднээс хүн төрөлхтөн дэлхий нийтээрээ авлигыг үл тэвчих үзэл санаан дор нэгдэж буй өнөө үед манай улс ч авлигатай тэмцэх идэвх санаачлагыг бүхий л талаар дэмжин, үндэсний хууль тогтоомжоо боловсронгуй болгож байна.

2003 оны 12 дугаар сард Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцид нэгдэн гарын үсэг зурах зорилгоор Мексикийн Мерида хотноо зохион байгуулагдсан Улс Төрийн Дээд Түвшний хуралдааны үеэр Авлигын эсрэг байгууллагуудын Олон Улсын Холбоог байгуулах санаачилгыг оролцогч орнуудын зүгээс анх гаргаж, 2006 оны 10 дугаар сард Бээжин хотноо зохион байгуулагдсан Авлигын эсрэг байгууллагуудын Олон Улсын Холбооны анхдугаар хуралдааны үеэр уг байгууллагыг албан ёсоор байгуулсан билээ.

Энэ нь улс орнуудын авлигатай хийх тэмцэл үндэсний болоод бүс нутгийн хэмжээнээс хальж, дэлхий нийтийн түвшинд уг үзэгдэлтэй тэмцэх аятай боломжийг бүрдүүлж өгснөөрөө чухал арга хэмжээ болсон юм.

Дээрх хуралдаанд дэлхийн 137 орны 1000 гаруй төлөөлөгч оролцож, Монгол улсын прокурорын байгууллага тус Холбооны санаачлагч-гишүүн байгууллага болсон нь манай байгууллагын төдийгүй Монгол улсын хувьд томоохон тэмдэглэлт үйл явдал болсон бөгөөд цаашид уг Холбооны үйл ажиллагаанд Монголын талаас оролцох оролцоог өргөтгөх зайлшгүй шаардлагатай байна.

Манай улсад сүүлийн жилүүдэд авлигын асуудлаар хийсэн удаа дараагийн судалгааны дүнгээс үзэхэд Монголын нийгэмд авилга түгээмэл байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Мөн 2005 онд Транспэрэнси Интернэйшнл олон улсын байгууллагаас улс орнууд дахь авлигын индексийг судлахад Монгол улс 159 орноос 85 дугаарт бичигдсэн зэрэгтэй харьцуулж дүгнэвэл нийт илрүүлсэн энэ төрлийн гэмт хэргийн тоо харьцангуй бага байгааг ч цаашид анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

Прокурорын байгууллага нь авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага хүлээн авсан үеэс эхлэн хуульд заасан үндэслэл журмын дагуу тасралтгүй хяналт тавьж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг шүүхэд нотлох чиг үүргийг хэрэгжүүлж байна.

2006, 2007 оны эхний 5 сарын байдлаар хээл хахууль авсан, хээл хахууль өгсөн, зуучилсан гэх 38 эрүүгийн хэрэгт прокурор хяналт тавьжээ. Үүнээс 17 хэргийг шүүхэд шилжүүлж, 11 хэргийг хэрэгсэхгүй болгож, 2 хэргийг түдгэлзүүлж шийдвэрлэсэн ба одоогоор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд 8 хэрэг шалгагдаж байна.

Авлигын эсрэг хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт зааснаар прокурорын байгууллага цаашид ч Авлигатай Тэмцэх Газрын гүйцэтгэх болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд Гүйцэтгэх ажлын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Прокурорын байгууллагын тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Авилгын хэргийг илрүүлэх, шалгаж шийдвэрлэх ажиллагаанд прокурорын үүрэг оролцоо нилээд чухал байр суурийг эзэлдэг. Үүнтэй холбоотойгоор прокурорууд мэргэжлийн өндөр түвшинд, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүйн боломжийг бүхий л талаар хангах явдал цаашид ч төрийн бодлогын хэмжээнд байх ёстой асуудлуудын нэг юм.

Шинээр батлагдсан Авлигын эсрэг хуулийн дагуу авлигын хэрэгт мөрдөн байцаалт явуулах ажиллагааг мэргэшсэн мөрдөн байцаагчид дагнан харьяалуулсан нь оновчтой шийдэл болсон гэж үздэг. Үүний нэгэн адилаар авлигын хэрэгт хийгдэж буй хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, гүйцэтгэх ажилд тавих хяналтыг тусгайлан эрх олгосон буюу дагнасан прокурор хэрэгжүүлэх нь энэ төрлийн гэмт хэргийг мэргэжлийн өндөр түвшинд шалгаж шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлнэ гэж үзэж байна.

Эдгээр мэргэшсэн прокуроруудыг сонгохдоо ажлын дадлага туршлага, нас тогтсон байдал, мэдлэг мэргэшил, ёс суртахууны хувьд шаардлага хангаж буй эсэхийг харгалзан сонголт хийх нь чухал юм. Эдгээр прокуроруудын хувьд зөвхөн мэдлэг, мэргэшлийн ур чадварыг нь дээшлүүлээд зогсохгүй тэднийг сэтгэл зүйн хувьд ч бэлтгэх зайлшгүй шаардлага байгаа юм.

Авлигын хэргийг шалган шийдвэрлэж буй мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх үүднээс тэдгээрийг тусгай хөтөлбөрийн дагуу системчилсэн сургалтанд тогтмол хамруулж, авлигын хэргийг мөрдөхтэй холбоотой нарийн арга техник эзэмшүүлэх хэрэгтэй байна. Тухайлбал,

төрийн удирдлагын болон санхүүгийн менежмент, өмч хувьчлал, бараа үйлчилгээ худалдан авах журмаас авахуулаад нуугдмал хөрөнгө илрүүлэх, нотлох баримт цуглуулах ажиллагааг хэрхэн гүйцэтгэх, гэрч хохирогчийг хэрхэн хамгаалалтанд авах арга барилыг ч нэг бүрчлэн зааж сургах нь чухал юм.

Гэмт этгээдүүд хууль бус аргаар олж авсан эд хөрөнгөө нуун дарагдуулах зорилгоор гадаадад гуйвуулан байршуулах аргыг өргөнөөр хэрэглэх болсон өнөө үед гадаад улсын хуулийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, тэдгээр хууль бус өмч хөрөнгийг илрүүлэхэд чиглэсэн эрх зүйн харилцан туслалцааг цаг алдалгүй шуурхай үзүүлж байх явдал нэн чухал байна.

Үүнтэй холбоотойгоор эрх зүйн туслалцаа үзүүлэх болон олон улсын гэрээ Конвенцуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулах, ялангуяа эрх зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр ажиллаж буй холбогдох ажилтнуудын мэргэшлийн ур чадвар болон гадаад хэлний мэдлэгийг сайжруулахад онцгой анхаарах шаардлагатай юм.

Түүнчлэн дээрх байгууллагуудын авлигын эсрэг бодлого боловсруулах чадавхийг нэмэгдүүлэхэд анхаарч үүнд чиглэсэн сургалт зохион байгуулах, бусад улс оронд мэргэжил дээшлүүлэх, туршлага судлуулах явдлыг төрийн зүгээс дэмжих нь зүйтэй юм. Авлигатай тэмцэх асуудлаар нилээд амжилтанд хүрсэн Гонконгийн жишээнээс үзэхэд мөрдөн байцаагч, прокурорын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад улсад туршлага судлуулж, сургалтанд хамруулах зорилгоор жилд дундчаар 4.7 сая ам. долларыг зарцуулж байгаа нь сургалтанд хэрхэн ач холбогдол өгч буйн тод жишээ юм.

Авлигын хэргийг хянан шийдвэрлэж буй хуулийн байгууллагын ажилтнууд нь зөвхөн мэргэжлийн хувьд биеэ авч явах ёс зүйн шаардлагыг хангаад зогсохгүй хувь хүний хувьд ч ёс зүйн өндөр шаардлагыг хангасан байх ёстой юм. Иймээс цаашид боловсон хүчнийг сонгон шалгаруулах журмыг боловсронгуй болгох, холбогдох байгууллагуудын Сахилгын Хороо болон Ёс зүйн Зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулахын зэрэгцээ Хуульчдад зориулсан Авилгын Эсрэг Хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах нь хуулийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, авилгаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үр нөлөөтэй арга хэмжээ байх боломжтой юм.

Авилгын хэргийг шалгаж шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтуудыг хуульд нарийвчлан тусгах хэрэгцээ шаардлага байсаар байна.

Авлигын гэмт хэрэг нь гол төлөв хаалттай хаалганы цаана үйлдэгдэж, гэрч, баримт цуглуулахад нэн түвэгтэй байдаг тул уг гэмт хэргийг илрүүлэхэд онцлог

арга барил шаардлагатай байдаг. Өөрөөр хэлвэл энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд гүйцэтгэх ажлын шугамаар нотлох баримт цуглуулах аргыг өргөн хэмжээгээр хэрэглэх шаардлагатай юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79 дүгээр зүйлд “эрүүгийн хэргийн талаар хуульд заасан үндэслэл журмын дагуу прокурорын зөвшөөрлөөр явуулсан гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан баримт сэлтийг нотлох баримтын хэмжээнд үнэлж болох ба ингэхдээ нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх үйл ажиллагааны эх сурвалжийг нууцална” гэж заасан байдаг.

Хуулийн энэхүү ерөнхий заалтыг цаашид нарийвчлан зохицуулж, гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан нотлох баримтуудыг хавтаст хэрэгт баримтжуулах журмыг тодорхой болгох зайлшгүй шаардлага бий болно.

Үүнээс гадна мэдээллийн нууцыг хадгалах, авилгын гэмт хэргийн талаар мэдээлэл өгсөн этгээд, гэрч, шинжээч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, уг гэмт хэргийн улмаас материаллаг болон материаллаг бус хэлбэрээр хохирсон бусад этгээдийн хохирлыг бүрэн хэмжээгээр нөхөн гаргуулах, хувь хүнээс гадна хуулийн этгээд авилгын төлөө хариуцлага хүлээх зэрэг Авлигын эсрэг НҮБ-ийн Конвенцид заасан нилээд хэдэн асуудлыг өөрийн хууль тогтоомждоо суулгаж, эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай байна.

Эцэст нь хэлэхэд авилгын үзэгдлийг таслан зогсооход зөвхөн хэргийг мөрдөж, шалгах ажиллагааг урьтал болгох биш, харин түүнээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд түлхүү анхаарч, авлигын тохиолдол бүрийг мэдээлдэг эрүүл тогтолцоог нийгэмд бий болгох явдал нэн чухал юм.

Улс орны хэмжээнд авлигатай хийх тэмцэл нь зөвхөн Авлигатай тэмцэх газар, шүүх, прокурорын үйл ажиллагаагаар хязгаарлах боломжгүй гэдэг нь ойлгомжтой юм. Авлигатай тэмцэх ажлыг тодорхой үр дүнд хүргэх нөхцөлийг бүрдүүлэхэд нийт төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа, хүчин чармайлт чухал бөгөөд ялангуяа авилгатай тэмцэх явдлыг бүхий л талаар хөхүйлэн дэмжих төрийн бодлогыг цаашид улам боловсронгуй болгох хэрэгтэй юм.

Анхаарал тавьсанд баярлалаа.